

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Т.ХИШИГБАЯРЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
	1	2	3	4	5	6	7	
		НЭГ. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ " ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
1	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	Төсвийн хэмнэлт, хувиар,		1.Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөн, батлуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлийг баримтлан төсвийг үр ашигтай зарцуулан ажилласан байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 15,285.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан. Үүнд: - Гаалийн хяналт бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом сум/ 785.2 сая төгрөг, - Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/ 14,500.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ батлагдан хэрэгжиж байна. Үүнд: - Гаалийн хяналт шалгалтын "Ухаалаг гарц" иж бүрдэл тоног төхөөрөмж 3,600.0 сая төгрөг, - Гаалийн хяналтын /рентген/ систем-10,900,0 сая төгрөг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Боомтын сэргэлтийн бодлого"-ын хүрээнд зарим боомтын бүтээн байгуулалтын ажил дуусаж, ашиглалтад орж байгаатай холбогдуулан гаалийн газар, хороодод нэн шаардлагатай байгаа гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж, шинээр	2024.01.01 2024.06.10	100	

				ашиглалтад орж байгаа Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгын тохижилтын тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлснээр Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр тушаалаар Сангийн сайдын багцаас • Зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ 962.5 сая төгрөг, • Хүний биеийн халуун хэмжигч, металл мэдрэх зориулалттай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ 490.0 сая төгрөг, • Хилийн боомтуудад ариутгалын байгууламж, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ 1,940.2 сая төгрөг, • Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгын тохижилт, тавилга хэрэгсэл /Увс, Улаангом/ 480.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг батлан худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх, тайлагнаж ажиллахыг Гаалийн ерөнхий газарт үүрэг болгосон. САНГИЙН САЙДЫН 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР ТУШААЛААР САНГИЙН САЙДЫН БАГЦААС БАТЛАГДСАН 3,872.7 САЯ ТӨГРӨГ Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Боомтын сэргэлтийн бодлого”-ын хүрээнд зарим боомтын бүтээн байгуулалтын ажлууд дуусаж, ашиглалтад орж байгаатай холбогдуулан: 1. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар бүтээн байгуулалтын ажил хийгдэж буй Гашуунсухайт боомтын ачаа тээвэр болон зорчигч тээврийн телехяналтын систем, Замын-Үүд боомтын ачаа тээврийн телехяналтын системийг Гаалийн ерөнхий газрын хяналтын нэгдсэн төвтэй холбох телехяналтын системийн тоног		
--	--	--	--	---	--	--

					төхөөрөмжийг солих, лиценз худалдан авахад шаардлагатай 2,408.1 сая.төгрөг; 2. Монгол Улсын хилийн боомтуудад шаардлагатай байгаа зорчигчийн ачаа тээш шалгах рентген төхөөрөмж худалдан авахад шаардлагатай 962.5 сая.төгрөг 3. Металл илрүүлэгч хаалга худалдан авахад шаардлагатай 490.0 сая.төгрөг; 4. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Боршоо боомт, Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын ажилд ариутгалын байгууламж, тоног төхөөрөмжийн зардал тусгагдаагүй тул ариутгалын байгууламж, тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай 1,940.2 сая.төгрөг; 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Увс аймгийн Улаангом сум дахь Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгыг энэ онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа тул тохижилтын тавилга хэрэгслийг худалдан авахад 480.0 сая.төгрөг, НИЙТ 6,280.8 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэх хүсэлтийг Монгол Улсын Сангийн сайдад Гаалийн ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/246 дугаар албан бичгээр хүргүүлснийг хангаж шийдвэрлэн, Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр тушаалаар “Хилийн боомтуудад телехяналтын тоног төхөөрөмж” 2,408.1 сая.төгрөгийн арга хэмжээг Сангийн яаманд, бусад 3,872.7 сая төгрөгийн 4 арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх, тайлагнахыг Гаалийн ерөнхий газарт үүрэг болгосон.		
--	--	--	--	--	---	--	--

				САНГИЙН САЙДЫН 2024 ОНЫ 74 ДҮГЭЭР ТУШААЛААР САНГИЙН САЙДЫН БАГЦААС БАТЛАГДСАН 1,870.0 САЯ ТӨГРӨГ Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэж, боомтын зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, нүүрс тээвэр, үнс, хог зайлуулах, албан хаагчид болон эрэлч нохойг зөөвөрлөхтэй холбоотой одоо ашиглагдаж буй автомашин, техник хэрэгслүүдийн ашиглалтын хугацаа дуусч, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байдалд хүрсэн, замын хөдөлгөөнд оролцох боломжгүй байдлыг Гаалийн ерөнхий газрын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/1086 дугаар албан бичгээр хүргүүлснийг хангаж шийдвэрлэн, Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 74 дүгээр тушаалаар “Гаалийн байгууллагын тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” 1,870.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх, тайлагнахыг Гаалийн ерөнхий газарт үүрэг болгосон.		
2	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Гаалийн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах (I-II улирал) 2.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний	Гаалийн байгууллага 2024 онд Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу 6 нээлттэй тендер, 19 харьцуулсан тендер, цахим дэлгүүрээс 1 худалдан авалт, 61 бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авахаар төлөвлөн Сангийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын Сангийн Сайдын 2024 оны 11, 2024 оны 74 дүгээр тушаалаар сайдын багцаас төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн, мөн Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн, газар, хороодын хэвийн үйл ажиллагааг хангуулах үүднээс төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт орох бүрт байгууллагын 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд	2024.01.01 2024.06.10	100

		дагуу ил тод нээлттэй зохион байгуулах (I-II улирал)	2 удаа тодотгол хийн, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд батлуулан ажиллаж байна. Тодотгосон төлөвлөгөөгөөр 27 нээлттэй тендер, 22 харьцуулсан тендер, цахим дэлгүүрээс 5 худалдан авалт, 65 бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авахаар төлөвлөгдөн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ-785.2 САЯ ТӨГРӨГ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Жагсаалт батлах тухай” 359 дүгээр тогтоолоор эрх шилжүүлэн Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг 2022 онд зохион байгуулсан ба он дамжин хэрэгжиж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Үндэсний аудитын газрын 2023 оны ГНАГ-2023/15-ШТА/НА кодтой “Гадна фасад болон техникийн нөхцөл өөрчлөгдсөнтэй холбоотой гадна шугам сүлжээний ажлын зураг төсөв өөрчлөгдсөн болон тарифт цалингийн өөрчлөлтөөс шалтгаалан төсвийг шинэчлэн баталгаажуулснаар төсөвт өртөг нэмэгдсэн” тухай гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгын ажил гүйцэтгэх ГЕГ/202201008 дугаар гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 456 дугаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу 491.7 сая төгрөгийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсныг энэ оны нэгдүгээр улиралд гүйцэтгэлээр олгосон. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ-14,500.0 САЯ ТӨГРӨГ <i>Гаалийн хяналт шалгалтын “Ухаалаг гарц” иж бүрдэл тоног төхөөрөмж</i>	
--	--	---	---	--

			Худалдан авах ажиллагааг 2019 онд зохион байгуулсан. Шивээхүрэн боомтын “Ухаалаг гарц” иж бүрдэл тоног төхөөрөмжийг 2022 онд, Замын-Үүд боомтын тоног төхөөрөмжүүдийг 2023 онд угсарч суурилуулан хүлээлгэн өгч, гаалийн хяналтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан энэ онд дуусгахаар ажиллаж байна. Ханги боомтод энэ онд угсарч суурилуулахаар Ажлын хэсгийн шийдвэр гарч, гэрээ байгуулах ажил хийгдэж байна. <i>Гаалийн хяналтын /рентген/ систем нийлүүлэх</i> Худалдан авах ажиллагааг 2019 онд зохион байгуулсан. Шивээхүрэн боомтод 2022 онд, Боршоо боомтод 2023 онд, Замын-Үүд боомтод энэ онд угсарч суурилуулж дуусган хүлээлгэж өгсөн. Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Булган боомтод 1 иж бүрдэл тоног төхөөрөмж хүргүүлсэн. Угсралт суурилуулалтын ажлыг эхлүүлж байна. Гашуунсухайт, Баянхошуу боомтуудад суурилуулахаар энэ онд нэмэлт гэрээ байгуулсан. САНГИЙН САЙДЫН 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР ТУШААЛААР САНГИЙН САЙДЫН БАГЦААС БАТЛАГДСАН 3,872.7 САЯ ТӨГРӨГИЙН 4 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ - Зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-962.5 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/131 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.04.15-ны өдөр нээлттэй зарлан 2024.05.07-ны өдөр нээхэд Масс теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан. Тендер шалгаруулалтад гомдол маргаан гараагүй.		
--	--	--	--	--	--

			- Хүний биеийн халуун хэмжигч, металл мэдрэх зориулалттай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-490.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/130 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.04.05-ны өдөр нээлттэй зарлан 2024.04.29-ний өдөр нээхэд Нанопланет ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан. Тендер шалгаруулалтад гомдол маргаан гараагүй. - Хилийн боомтуудад ариутгалын байгууламж, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-1,940.2 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/318 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг зарлахаар баримт бичгийг бэлтгэх ажил хийгдэж байна. - Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгын тохижилт, тавилга хэрэгсэл /Увс, Улаангом/-480.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/170 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.28-ны өдөр нээлттэй зарласан. 2024.06.18-ны өдөр нээнэ. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу ерөнхий гэрээ байгуулсан цахим дэлгүүрээс Ухаалаг самбар 65" 2 ширхэг, Зөөврийн компьютер /i7/ 8 ширхэг, Олон үйлдэлт принтер 23 ширхэг, Суурин компьютер /i7/ 25 ширхэгийг тус тус худалдан авахаар гэрээ байгуулсан. САНГИЙН САЙДЫН 2024 ОНЫ 74 ДҮГЭЭР ТУШААЛААР САНГИЙН САЙДЫН БАГЦААС БАТЛАГДСАН 1,870.0 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ		
--	--	--	--	--	--

			Зөвшөөрөл олгон, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчит эд хөрөнгийг олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлэх тухай 01/1891 тоот албан бичиг 2024.05.13-нд Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. БАЙГУУЛЛАГЫН УРСГАЛ ТӨСӨВ Гаалийн байгууллагын урсгал төсвөөр энэ оны эхний хагас жилийн байдлаар нээлттэй 22, харьцуулалтын аргаар 22, ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс 1 нийт 45 тендер зарлахаар төлөвлөн, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнээс Гаалийн ерөнхий газарт нээлттэй 9, харьцуулалтын аргаар 3, ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс 1 байна. 1. Цацрагийн хяналтын төхөөрөмж шилжүүлэн суулгах засвар /Алтанбулаг, Боршоо/-306.0 сая төгрөг Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/202 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендер амжилтгүй болсон тул Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.06-ны өдөр дахин нээлттэй зарлаж, 2024.05.27-ны өдөр нээхэд Масс Теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан. Тендер шалгаруулалтад гомдол маргаан гараагүй. 2. Гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмжүүдийн засвар-290.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/186 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.24-ны өдөр нээлттэй зарласан. 2024.06.14-ний өдөр нээнэ. 3. Гаалийн мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах техник хэрэгсэл-2,820.0 сая төгрөг.		
--	--	--	---	--	--

			Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/250 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.29-ний өдөр нээлттэй зарласан. 2024.06.27-ны өдөр нээнэ. 4. Гаалийн мэдээллийн системд ашиглагдах программ хангамжийн лиценз-1,000.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/251 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.29-ний өдөр нээлттэй зарласан. 2024.06.27-ны өдөр нээнэ. 5. Гаалийн улсын байцаагчдын дүрэмт хувцас, дагалдах хэрэгсэл нийлүүлэх-2,300.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/242 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.05-ны өдөр нээлттэй зарласан. 2024.07.03-ны өдөр нээнэ. 6. Лабораторийн зориулалттай тоног хэрэгсэл болон урвалж бодис, стандарт дээж нийлүүлэх-1,000.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/252 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.06.10-ны өдөр нээлттэй зарласан. 2024.07.01-ний өдөр нээнэ. 7. Бүрдүүлэлтийн цахим төвийн засвар-680.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/340 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг зарлахаар баримт бичгийг бэлтгэх ажил хийгдэж байна. 8. Бүрдүүлэлтийн цахим төвийн камержуулалт-330.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/341 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан.		
--	--	--	---	--	--

			Тендерийг зарлахаар баримт бичгийг бэлтгэх ажил хийгдэж байна. 9. Гаалийн ерөнхий газрын шуурхай хяналтын төв болон гаалийн төв лабораторийн харуул хамгаалалтын үйлчилгээг гүйцэтгэх-153.6 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/241 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.07-ны өдөр нээлттэй зарлаж, 2024.05.28-ны өдөр нээхэд Шүтээн уул ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан. 10.Шатахуун нийлүүлэх-50.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/121 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. 2024.02.20-ны өдөр зарласан тендер амжилтгүй болсон тул дахин Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.03.05-ны өдөр нээлттэй зарлаж, 2024.03.12-ны өдөр нээхэд Шунхлайтрейдинг ХХК, Петростар ХХК-иуд тендер ирүүлснийг үнэлэн, Петростар ХХК-ийн ирүүлсэн тендерийг хамгийн сайг үнэлэгдсэн тендерээр шалгаруулж гэрээ байгуулсан. Тендер шалгаруулалтад гомдол маргаан гараагүй. 11. Албаны эрэлч нохойд зориулалтын хоол нийлүүлэх-100.0 сая төгрөг. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/185 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.03.29-ний өдөр нээлттэй зарлаж, 2024.04.05-ны өдөр нээхэд Аз болор мөнх трейд ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан. Тендер шалгаруулалтад гомдол маргаан гараагүй. 12. Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс-30.0 сая төгрөг. Үнэлгээний хороо байгуулах ажил хийгдэж байна. 13. Гаалийн хяналт, шалгалтын нэг удаагийн троссон ломбо нийлүүлэх-500.0 сая төгрөг.		
--	--	--	---	--	--

					Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу ерөнхий гэрээ байгуулсан барааг цахим дэлгүүрээс худалдан авсан.		
3	Төсөв, санхүүгийн, шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		"Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу шилэн дансны цахим хуудсанд байрших тайлан, мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлэн ажилласан байна. (I-II улирал)	Шилэн дансны цахим хуудсанд байрших тухай бүрт оруулах мэдээллийн хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл бүлгийн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт хэсэгт Гаалийн ерөнхий газраас зохион байгуулсан тендерийн мэдээллийг тухай бүрт нийт 6 удаа байршуулж ажиллалаа.	2024.01.01 2024.06.10	100
4	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. (I-II улирал)	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлт 1.1.8 "Гаалийн хяналтын бүсүүдэд ухаалаг гарц, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген болон хяналтын төхөөрөмж, лаборатори байгуулах" үйл ажиллагааны хүрээнд Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан ухаалаг гарц иж бүрдэл тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах ажлын гүйцэтгэл 76,1 хувийн гүйцэтгэлтэй, энэ оны 6 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Мөн Дорноговь аймгийн Ханги боомтод ухаалаг гарц иж бүрдэл тоног төхөөрөмжийг суурилуулахаар ГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/191 тушаалаар байгуулагдсан Гаалийн шинэчлэлийн	2024.01.01 2024.06.10	100

					хүрээнд хэрэгжиж буй Гаалийн хяналт шалгалтын “Ухаалаг гарц” иж бүрдэл бүхий тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсарч суурилуулах, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсгээс шийдвэрлэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.		
5	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. (I-II улирал)	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмуудыг мөрдөн ажиллаж байна.	2024.01.01 2024.06.10	100
6	Үүрэг даалгавар	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Өгөгдсөн үүрэг даалгаварыг заасан хугацаанд хэрэгжилтийг ханган тайлагнан ажилласан байна. (I-II улирал)	ГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/191 тушаалаар байгуулагдсан Гаалийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжиж буй Гаалийн хяналт шалгалтын “Ухаалаг гарц” иж бүрдэл бүхий тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсарч суурилуулах, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.	2024.01.01 2024.06.10	100
7	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Ажлын цаг ашиглалт 100 хувь байна. (I-II улирал)	Ажлын цаг 100 хувь ашиглан ажилласан. Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй.	2024.01.01 2024.06.10	100
ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”							
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		1.ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж	1.ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан.	2024.01.01 2024.06.10	100

	батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх			батлуулсан байна. 2.Төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана. 3.Шаардлагатай бусад тоо баримт мэдээг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллана. (I-II улирал)	2.Төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. 3.Шаардлагатай бусад тоо баримт мэдээг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.		
2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		1.2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулийн хугацаанд ХАСХОМ-ын системд мэдүүлсэн байна. 2.Гадаад, дотоодын байгууллага болон газар, хороодоос ирсэн албан тоотын	1. 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулийн хугацаанд ХАСХОМ-ын системд мэдүүлсэн. 2. 2024 оны эхний хагас жилийн байдлаар хариутай болон хариугүй 29 албан бичиг хүлээн авч шийдвэрлэсэн, 23 албан бичиг боловсруулан хүргүүлж ажилласан байна. 3. 2023 оны Гаалийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхийг бэхжүүлэх видео сургалтын материал бэлтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материал 1 боть Гаалийн ерөнхий газрын хяналтын нэгдсэн төв болон гаалийн төв лабораторийн барилгын цахилгааны аваарын нөхцөлд ажиллах генератор нийлүүлэх,	2024.01.01 2024.06.10	100

	хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх			хариу шийдэж өгөх (I-II улирал)	угсрах, суурилуулах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн материал 2 боть Гаалийн салбар лабораториудад лабораторийн зориулалтын тоног харэгсэл болон урвалж бодис, стандарт дээж нийлүүлэх нийлүүлэгчийг шалгаруулах тендерийн материал 2 боть Гаалийн ерөнхий газрын хяналтын нэгдсэн төв болон гаалийн төв лабораторийн харуул хамгаалалтын үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материал 1 боть Гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/ нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн материал 1 боть 2022 оны Гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн эрэлч нохойг зориулалтын нохойн хоолоор хангах, худалдан авах гег/202201003 харьцуулалтын тендерийн материал 1 ботийг тус тус архивын нэгж болгон хүлээлгэж өгсөн.		
3	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. (I-II улирал)	Сангийн яамны агентлагийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх хяналт шалгалтын ажлын хэсэгт Гаалийн байгууллагын 2022, 2023 оны худалдан авах ажиллагааны материалыг бэлтгэн шалгуулсан. Монголын Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гаалийн байгууллагад 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилт, үр дүнгийн судалгаа гаргаж өгсөн.		

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтанд хамрагдах			Сургалтанд хамрагдсан байна.	Сангийн яамнаас жил бүр зохион байгуулдаг "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба цахим шинэчлэл" сургалтанд хамрагдлаа.	2024.01.01 2024.06.10	100
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх			Хэрэгжилт, гүйцэтгэлээр	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг судлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	2024.01.01 2024.06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
Албан тушаал)

Т.ХИШИГБАЯР / /
(Нэр, гарын үсэг)

2024 - 06 - 10
(Огноо)

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦАГЧ ТӨМӨРБААТАР ОВОГТОЙ ХИШИГБААРЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1. ГҮЙЦЭТЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2	3	4
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	55	6	61	
2.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	55	6	61	
3.	Төсөв, санхүүгийн, шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	60	10	70	
4.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	55	5	60	
5.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт.	55	5	60	
6.	Үүрэг даалгавар	60	6	66	
7.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
8.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон	60	10	70	

	хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				
9.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	60	10	70	
10.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	
Дундаж оноо: 64.8					

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАД ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	1	2	3	4
1.	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтад хамрагдах	87	13	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	87	13	
Дундаж оноо: 13				13

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	5	
3.	Хариуцлагатай байдал	6	
4.	Дүн шинжилгээ хийх	5	
5.	Ажлын цаг ашиглалт	6	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			

6	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
Дундаж оноо: 6		6	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиглах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг баалгаваар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	64.8
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн дарвын үнэлгээ)	6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо =		91.8

(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн дарвын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо

Үнэлгээ өгсөн:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (албан тушаал)

Нэгжийн дарга

(гарын үсэг)

Д.Долгорсүрэн/
(албан хаагчийн нэр)

2024.08.10 (огноо)

Үнэлгээтэй таншцаж, зөвшөөрсөн:

Гаалийн улсын байцаагч (албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

(гарын үсэг)

Л.Т.Хишигбаяр/

(албан хаагчийн нэр)

2024.08.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ажлаагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

/Г. Энхтайван/

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.09.26 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн
даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

/Ж. Баясгалан/

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.02.26 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)

/Р. Отгонжаргал/

2024.03.26 (огноо)

